



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/452

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 55 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202307062 дугаартай Солонго хорооллын дунд замын уулзвараас Стадион хүртэл авто зам татах ажлыг "Хайчийн нуруу" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

